

Орчуулгын онол практикийн асуудалд Б.Явуухулангийн

“Би хаана төрөө вэ?” шүлгийн утга дүйлгэц

(Саймон болон Букинагийн хувилбар)

Н.Оюун-Ундраа /МУИС, ГХСС- ГХСТ/

Товч агуулга: Энэхүү өгүүлэлдээ Бэгзийн Явуухулангийн “ Би хаана төрөө вэ?” алдартай шүлгийн эхийг Саймоны англи орчуулга, Букинагийн орос орчуулгатай жишиж тулгасан болно. Уг шүлгийн долоо болон наймдугаар бадгийн орчуулгыг жишсэнээр орчуулгын алдаа оноог дэнслэн, үүний зэрэгцээгээр зарим нэг боломжит өөрийн хувилбарыг санал болгосон байна. Ийнхүү англи, орос орчуулгыг монгол эх шүлэгтэй нь тулгаж задлан шинжилснээр монголоос англи руу орчуулах орчуулгын онолын зарчмын асуудлыг боловсруулах, практик үйл ажиллагааг сайжруулахад бага ч атугай тус дөхөм үзүүлэх зорилготой юм.

Түлхүүр үгс: орчуулгын онол, орчуулгын онолын үзэл баримтлал, үндэсний ахуйн болон сэтгэхүйн онцлог, утга гээгдэх болон гуйвах, орчуулгын найруулгын өнгө аяс, найруулгын өвөрмөц онцлог

Б.Явуухулан амьд сэрүүн цагтаа “...би “Би хаана төрөө вэ?” шүлэгтээ илүү хайртай. Энэ шүлэгт би эх орны тухай, хайрт бүсгүйн тухай бичсэн юм.

Эх орон гэдэг бол: бойжсон өлгий, төрүүлсэн эх, хайрт бүсгүй, үр хүүхэд цөмөөрөө юм.”⁷⁹ гэж хэлсэн байдаг.

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Н.Жамбалсүрэн: “Би хаана төрөө вэ?” гэдэг шүлэг нь чөлөөт орны жаргалтай иргэний бахархах, баясах, бүтээх сэтгэл төрүүлнэ. Үүнийг уншихад хаана ч байж мэдэх ямар нэг сайхан газар биш,... монгол нутаг санаанд ургадаг юм” гэж хэлсэн байдаг⁷⁹.

Ер нь олон судлаач энэ зохиолыг монголын орчин үеийн уянгын яруу найрагт тодорхой алхам болсон гэж үздэг юм байна. Тиймээс ч Болгарын утга зохиол судлаач Цветанка Тафаржийска зохиогчийг нь “Монголын орчин үеийн уянгын яруу найргийн өвөг эцэг”⁸⁰ гэж нэрлэжээ. Эх орны тухай санаа сэдэв сэрэл сэтгэмж нь яруу найрагчийн урлан бүтээх онгодыг байнга урин дууддаг төдийгүй түүний оюун санаа, сэтгэл бодлыг

⁷⁹ “Сэтгэл татах яруу найраг”, “Үнэн”, 1967 оны 7-р сарын 11 №192 10187

⁸⁰ Монголын орчин үеийн яруу найраг , “Гадаадынхан монголын уран зохиолын тухай” номд УБ..1977 319-320 дахь тал

насан туршид баяжуулан авъяас билгийг нь үргэлжид хөгжөөн төгөлдөржүүлсээр байдаг далдын увьдис, хүч чадалтай ажээ.⁸¹

Уран зохиол судлаачид энэ зохиолыг шүлэг, дуулал, найраглал гэхчлэн төрөл зүйлд хамааруулж байна.

Энэ зохиолын зарим бадагт хөгжмийн зохиолч Ж.Шараа ая хийсэн бөгөөд зохиогчид нь БНМАУ-ын Төрийн шагнал олгох тухай тогтоолд энэ зохиолыг нэр цохсон байдаг байна. БНКУ-д хэвлэгдсэн Б.Явуухулангийн шүлгийн түүвэр ч мөн энэ зохиолын нэрээр нэрлэгджээ.

Б.Явуухулангийн дотны найз, ЗСБНХУ-ын социалист хөдөлмөрийн баатар, Төрийн хошой шагналт яруу найрагч А.Сафронов яруу найрагчийн тухай “Баруун Монголд малч ардын гэрт төрсөн болохоор “Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би” гэж хэлэх бүрэн эрхтэй байсан юм”⁸² гэж хэлсэн байдаг.

Найрагчийн хайртай энэ шүлгийг хуучнаар Зөвлөлтийн яруу найрагч И.Федорины орчуулгаар “Лирика”(1960) түүвэрт анх хэвлэн гаргаж байжээ. Харин дараа нь 1985 онд Л.Букина энэ шүлгийг “Где я родился” нэртэйгээр орчуулан “Из Монгольской Поэзии XX века” номд хэвлүүлэн гаргасан байна.

Хамгийн анх “Би хаана төрөө вэ?” шүлгийг манай нэртэй орчуулагч, толь бичиг зохиогч Д.Алтангэрэл 1986 онд англи хэлнээ орчуулж, “Modern Mongolian Poetry” номдоо хэвлүүлсэн байдаг. Харин 2009 онд Саймон Уикхэм Смит орчуулан “Mongolian verse”, the collected poems of Begziin Yavuuhulan, номдоо хэвлүүлэн гаргажээ. Энэ нь уг шүлгийн англи орчуулгын гурав дахь хувилбар нь болсон байна.

Яруу найрагийн орчуулгын талаар Оросын нэрт зохиолч, гарамгай орчуулагч К.Чуковский “Хувийнхаа туршлагаас бодож үзэхэд миний оролддог уран зохиолын бүхий л төрөл зүйлээс хамгийн төвөгтэй нь шүлэг орчуулах ажил.”⁸³ гэж бичсэн байдаг. Харин орчуулагч, орчуулгын онолч А.Шархүү “Нэг хэлнээс нөгөөд уран зохиол орчуулж байгаа хүн тухайн тэр зохиолд “юуны тухай” өгүүлж байгаа агуулгыг төдийгүй, энэ агуулгаа чухам “яаж”, уран сайхны ямар арга хэрэглүүрээр дамжуулан гаргасныг бас эх хэлээрээ дүрслэн буулгах учиртай. Чухам энэ утгаараа орчуулагч хүн бол орчуулж байгаа зохиолыг хамтран зохиогч нь, тэр зохиолыг бичсэн эзний өрсөлдөгч нь болдог гэж үздэг байна. Ялангуяа яруу найргийн зохиол орчуулах хүнд эх зохиолын агуулга, хэлбэр үзэл санаа, дүр дүрслэлийг нэг ерөнхий цөмд зангидаж өгөх үүрэгтэй, өөр хоорондоо нарийн зохицсон айзам хэмжээ, холбоц, дотоод нугарал, хөг аяс хийгээд,

⁸¹ Ц.Мөнх, “Б.Явуухулангийн яруу найргийн туршлага”, УБ, 1990 он, хуудас 51

⁸² Литературная газета, №9. 3 марта 1982г

⁸³ К. Чуковский. “Высокое искусство”, М.,1964

үг хэллэг санааг нэг бүрчлэн буулгах нэр хүндтэй бөгөөд амаргүй зорилт тулгардаг. ”⁸⁴ гэж бичжээ.

Ер нь яруу найргийг нэг хэлнээс нөгөө хэл рүү буулгахад, ялангуяа эх хэлнээс нөгөө хэл рүү орчуулахад орчуулагч хүн яс хэл зүйн дүрмээр бус, харин түүнээс гажиж бичих найруулгын өвөрмөц онцлогийг ч төрөлх хэлтэн шиг мэдэрч, найруулан бичих олон хувилбар, шадын доторх үг болон нийлэмж үгсийн шилжих хөдөлгөөн, тэдгээрийн байрлал, шүлгийн утгын хэлхээс буюу шүлгийн гол нуруу болох шадын байрлалын бүх л боломжит хувилбарууд болон сэлгэлтэнд ч чөлөөтэй хөвөрч чаддаг байх ёстой болов уу. Үүгээрээ яруу найраг орчуулах найруулгын болон бичлэгийн арга барил нь шулуун шугаманд буюу хэвтээ тэнхлэгт бичигддэг үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгаас огт эсрэгээрээ босоо тэнхлэгт байна. Нэг ёсондоо энэ нь орчуулгын онолын үүднээсээ хэл зүйн болон үгсийн сангийн хувиргал бөгөөд үргэлжилсэн үгийн зохиолд огт хэрэглэгддэггүй гэсэн үг биш бөгөөд гагцхүү шүлэг, яруу найргийн орчуулганд илт давуутай хэрэглэгдэж байгаагаараа онцлогтой юм.

Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ”⁸⁵ шүлгийн Саймоны англи орчуулга болон Л.Букинагийн⁸⁶ орос хэл рүү орчуулсан орчуулгыг утга дүйлгэцийн хувьд эх шүлэгтэй нь тулгаж үзье. Гэхдээ эх шүлэг маань арванхоёр бадагтай, бадаг бүр нь таван шадаас бүрдсэн нилээн урт учраас бүх бадагийг тулгаж үзэх боломжгүй тул зөвхөн долоо болон наймдугаар бадагийг харьцуулан авч үзэх болно.

Долдугаар бадаг буюу,

Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би:

Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд,

Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд

Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би. – мөрүүдийг Саймон:

I took my birth in the mind of a beautiful woman,

In the tenderness of her gaze, among her lashes,

In the lapping folds of her deel, reeking of milk.

And, in her modesty, in her thoughts, and in her thoughts,

I took my birth in the mind of a beautiful woman. – буюу

МОНГОЛЧИЛБОЛ:

Сайхан бүсгүйн бодолд би төрлөө,

Сормуусан дундах харцны нь ялдамханд

⁸⁴ А. Шархүү “Үндэстний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал”, УБ, 2005 он

⁸⁵ Б.Явуухулан “Түүвэр зохиол”, УБ, 1985 он, 387 хуудас

⁸⁶ “Из монгольской поэзии XX века”, М., 1981 он, хуудас 152-154

Сүүний үнэр нэвширсэн (!) дээлийнх нь өвөр хэсгийн нугалаасанд
Түүнийхээ даруухан зан, оюун бодол болон оюун бодолд нь
Сайхан бүсгүйн бодолд би төрлөө, – гэж орчуулсан байна.

Саймон “*төрөхийг*” зүгээр ч нэг бусдаар үйлдүүлэх хэв буюу Passive Voice-оор үгчилбэл, ‘төрөгдөх’ буюу “*be born*” гэж оноосонгүй, харин “*take one’s birth*” гэж дүйцүүлжээ. Уг хоёр нийлэмж үгсийн хооронд утгын нарийн ялгаа бий. “*Take one’s birth*” гэсэн нийлэмж үгэнд “*be born*” гэсэн нийлэмж үгийг бодвол тухайн газар төрөхөө өөрөө зориудаар сонгож авах гэсэн утга давхар агуулагдаж байна.

Түүнчлэн Саймоны бүх бадгийн орчуулгаас эх шүлэгт байгаа “эзэгнэнхэн” гэдэг үг ор тас гээгджээ. Хэдийгээр ганц л үг боловч гагцхүү ганцхан энэ үг л эх шүлэгт эх орноороо бахархах, эзэн болж төрснөөрөө аархаж омогших сэтгэлийг нэвт шингээж өгч байсан нь орчуулган дээрээ хаягдсанаас болж монгол хүний төрсөн нутгаараа бардамнаж омогших сэтгэл уг шүлгээс бүрмөсөн арчигдсан байна.

“Ганцхан үгнээс орчуулгын хувь заяа төдийгүй орчуулагчийн уран бүтээлийн хувь заяа шалтгаалдаг учир ч бий гэж хуучнаар Зөвлөлтийн нэг орчуулагч бчисэн нь түмэн үнэн үг билээ”⁷⁹ гэж нэртэй орчуулагч Ц.Хасбаатар хэлсэн нь маргаангүй үнэн билээ. Мөн үг оноох гэдэг тун нарийн чимхлүүр ажил болох тухайд “Үг гэдэг өөрийн хөг аялгуутай, утга санаатай, уран дүрслэлтэй байдаг учир эх бичгийн чухамхүү тэр хам сэдэвт л таарах цорын ганц үгийг олон шигтгэж өгөх нь орчуулагчийн гол зорилго байдаг.”⁸⁷ гэж манай нэрт орчуулагч, орчуулгын онолч Г.Аким тодорхойлжээ.

Мөн цааш нь тэрвээр “Аливаа зохиолыг орчуулахад дүйлгэх асуудлыг гурван түвшинд авч үзэх хэрэгтэй болдог. Нэгдүгээрт, үг, нийлэмж үгийн түвшинд тохирч байх. Энэ нь үгийн утгыг зөв оноож, найруулгын нь өнгө аясыг тааруулан, уран дүрслэлийг нь тохируулна гэсэн үг юм.....Хоёрдугаарт, өгүүлбэрийн түвшинд тохирч байх. Үүнд гадаад хэлний өгүүлбэрийн утгыг буулгаж, илэрхийлж байгаа өнгө аясыг гаргах нь чухал болно. Ингэхэд өгүүлбэрийн утга нь үлдээд, хэлбэр бүтэц нь өөрчлөгддөг.....Гуравдугаарт, бүхэл зохиолын түвшинд дүйж байх. Энэ нь зохиолчийн номдоо гаргасан санаа, дүр, үзэл санаагаа илэрхийлсэн арга, зохиолчийн өвөрмөц найруулгыг, өөрөөр хэлбэл, уг номын уран сайхныг ягштал буулгасан байх хэрэгтэй гэсэн үг болно.”⁸⁸ гэж хэлсэн нь ч бий.

“Эзэгнэнхэн” гэдэг үгэнд орсон монгол хэлний үйл үгийн –хан, -хэн, -хон, -хөн нөхцөл нь тухайн үйл үгийн бахдах, бахархах, бардамнах өнгө аястай чимхлүүр утгыг илэрхийлдэг. Харин энэ утгын нарийн ялгааг англи хэлэнд хэрхэн буулгах нь нилээн ярвигтай зүйл байж мэдэх ч ор тас боломжгүй зүйл ч бас биш юм. Төрөл хэлний аймгийн хувьд, манай монгол хэл нь алтай хэлний аймагт багтдаг бөгөөд хэл

⁸⁷ Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, УБ., 2009 он, нэмж засварласан хоёр дахь хэвлэл, хуудас 22

⁸⁸ Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, УБ., 2009 он, нэмж засварласан хоёр дахь хэвлэл, хуудас 8

шинжлэлчид монгол хэлийг *agglutinative* буюу залгамал хэл (заримдаа дэлгэмэл хэл ч гэж нэрлэдэг) гэж үздэг бол англи хэл нь Энэтхэг-Европ хэлний аймагт багтдаг, *inflected* буюу дотроо нугалмал хэл юм⁸⁹.

Тэс өөр хоёр хэлний аймагт хамааралтай, хэлний бүтэц байгууллын эрс ялгаатай онцлог шинжээсээ шалтгаалаад англи хэлний үйл үгэнд монгол хэлтэй адил нөхцөл дагавар залгаад тухайн үйл үгийн үгсийн сангийн үндсэн утгаас гадна бахархах бахдах утгын өнгө аясыг хослуулан илэрхийлэх ямар ч арга байхгүй. Гэвч үйл үгийг тодорхойлдог *adverb* буюу дайвар үгтэй хавсарч байж энэ утгыг гаргаж болно. Өөрөөр хэлбэл, эзэгнэх гэдэг үгийг англиар *to reign over*⁹⁰ гэж оноогоод эзэгнэнхэн гэх утгы нь *proudly reigning over* буюу бардаагаар эзэгнэн гэж буулгахад болох мэт санагдана.

Саймон сэтгэл гэдэг үгийг *heart* гэж авсангүй, оюун бодол буюу *mind* болгож орчуулжээ. Харин, *Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд* - гэсэн мөрийг *In the tenderness of her gaze, among her lashes* буюу *Сормуусан дундах харцны нь ялдамханд* гэж англиар гайхамшигтай ончтой бөгөөд уянгалаг, сонсголонтой орчуулсныг зориуд цохон тэмдэглэх хэрэгтэй.

Гэвч гуравдугаар мөр буюу,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд - гэсэн шадьг

Сүүний үнэр нэвширсэн дээлийнх нь өвөр хэсгийн нугалаасанд- гэж орчуулсныг гайхалтай муу орчуулжээ гэж хэлэхээс өөр ямар ч арга алга. Ерөөс энэ шадьг төдийгүй бүхэл бадагийн утга, уянгын хөг, өнгө аясыг бүхэлд нь эвдсэн цорын ганц үг бол “ханхлах” гэдэг үгийг орчуулахдаа “нэвшрэх” гэдэг үгийг сонгож авсанд оршино. Энэ нь Саймоны хийсэн хамгийн том алдаа бөгөөд “ханхлах” гэдэг үгийг оноохдоо яагаад ч үл хэрэглэж болох сөрөг өнгө аястай, (сэжиг хүрэм) нэвширэх гэдэг утга бүхий “*reek of*”⁹¹ гэсэн үйл үгээр оноосон явдал юм. Ийм байж боломгүй, бүдүүлэг алдаа хийснээрээ Саймон манай малчин монголчуудын олон зуун жил малын сүү ууж, түүнийгээ янз бүрийн уламжлалт аргаар боловсруулан, хоол хүнсэндээ идэж хэрэглэж ирсэн зан заншил болон сүүг ариун цагааны бэлэгдэл болгон эрхэмлэн дээдэлж ирсэн монголчуудын сэтгэхүйн онцлогийг огт мэддэггүйгээ илтгэн харуулсан байна. Төрөлх англи хэлтнүүдийн хувьд сүүний үнэрийг ханхлах биш нэвшрэх гэсэн утгаар ярих нь ямар ч гоо сайхны таашаал төрүүлэх нь битгий хэл харин ч бүр гайхан сэжиглэж, цэрвэх таагүй сэтгэгдлийг төрүүлж байна.

Үг оноох талаар орчуулагч, орчуулгын онолч Г.Аким “Үг гэдэг үл үзэгдэх түм буман шижмээр эх хэлнийхээ утга зохиол, соёлын уламжлалтай холбоотой байдаг.

⁸⁹ Google’s, Wikipedia, Free Encyclopedia, History of English Language

⁹⁰ New Oxford Advanced Learner’s Dictionary, 2007, page 1257

⁹¹ Oxford Advanced, 2007 он, хуудас 1269

Тодруулан хэлбэл, үг гэдэг тухайн өгүүлбэр, хэсэг, зохиолтойгоо, цаашилбал, тухайн зохиогчийн бүх уран бүтээлтэй, бүр лавшруулбал, тухайн утга зохиол, тэр ч байтугай тухайн соёл иргэншлийн хүрээтэй холбоотой байдаг”⁹² гэж хэлсэн байдаг.

Харин дөрөвдүгээр мөр буюу,

Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд -гэсэн шадыг

And, in her modesty, in her thoughts, and in her thoughts- буюу монголчилбол:

Түүнийхээ даруухан зан, оюун бодол болон оюун бодолд- гэж үг давтах аргаар утгад хүч нэмэгдүүлэн хувиргаж орчуулсан нь эх шүлгийн утгатай харьцуулахад ядруухан орчуулга болжээ гэж хэлэхэд нэг их хилсдэхгүй биз ээ.

Харин Букина энэ бадгийг,

Я владыкой любви темноглазой монголки родился,

Мягкий терлик вокруг ее тонкого стана обвился,*

Робкий взгляд ее светится мне сквозь ресницы,-

Ласк горячих и нежных наивная юность стыдится.

Да, владыкою сердца монголки на свет я родился!— буюу монголчилбол:

Хар нүдэн монгол бүсгүйн хайрыг эзэгнэгч болж би төрлөө

Зөөлөн тэрлэг нь туяхан гоолиг биеий нь барина

Сормуусан дундах аймхай нүд нь надад гэрэлтэнэ

Халуухан болоод энхрийхэн энхрийлэлтэнд гэнэн залуу нас ичингүйрнэ

Тиймээ, Монгол бүсгүйн зүрх сэтгэлийг эзэгнэгч болж энэ хорвоод би төрлөө— гэсэн байна. Саймоныг бодвол Букинагийн орчуулгад “эзэгнэнхэн” гэдэг үгийг яг тэр утгаар нь “владыкой”⁹³ гэж орчуулсан нь тун ончтой болжээ. “Зохиолын уран үг хэлний асуудалд үгсийн сангийн онцгой үгс, утга шилжүүлэх ёс зэргээс гадна үргэлжилсэн үгийн болон яруу найргийн зохиол аль нь ч хэл зүйн хууль дүрмийн дагуу хэрэглэхээс өөр маягаар зохиолыг улам уран яруу болгохын үүднээс зориуд оруулан ашигладаг өгүүлбэр зүйн уран маяг (синтаксические фигуры) гэж байдаг. Өгүүлбэр зүйн олон уран маягт зүйл бүрийн давтах маяг орно... өгүүлбэр юмуу шадын эхийг сүүлд нь давтах бөгжин давтал (кольцо) гэж байдаг”⁹⁴ байна.

Эх шүлэгт эхний мөрүүд бадгийн сүүлд давтагддаг буюу бөгжин давталттай бол Букина орчуулгандаа бадгийн сүүлийн давталтыг зүгээр нэг байгаа чигээр нь давтах биш, нилээн хүч нэмэгдүүлсэн утга оруулж, өгүүлбэрийн гишүүдийг тонгоруу маягаар байршуулан, найруулгын өвөрмөц онцлогтойгоор бичсэн нь маш оновчтой болсныг онцолж хэлэх хэрэгтэй болов уу. Саймон ч бас сүүлчийн мөрөөр бөгжин давталт

⁹² Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, УБ, 1984 он, хуудас 23

⁹³ Russian-English Dictionary, М., 1965 он, хуудас 78

⁹⁴ С.Дулам, Ц.Хасбаатар, “Уран зохиолын онолын үүд”, УБ, 1980 он, хуудас 163

хийхдээ Букина шиг ийм найруулгын өвөрмөц онцлогтойгоор англи хэл рүү буулгаж бүрнээ болох байсан.

Мөн Букина энэ орчуулгадаа “сайхан бүсгүйг” хар нүдэн монгол бүсгүй болгон өөрчилж, эх шүлгийн хоёр болон гуравдугаар мөрийн байрыг орчуулган дээрээ сэлгэн, утгын хувьд ч мөн их л өөрөөр дүрсэлсэн байна.

Өөрөөр хэлбэл,

Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд- гэсэн мөр нь

Сормуусан дундах аймхай нүд нь надад гэрэлтэнэ- болж хувирч,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд- гэсэн мөрийг

Зөөлөн тэрлэг нь туяхан гоолиг биеийг нь барина- гэж утгын хувьд эх шүлгийн утгаас ихэд өөрчлөн бичсэн боловч зарим талаараа, ялангуяа эх шүлгийн хоёрдугаар мөрний утгыг гуравдугаар мөрөн дээр ямартаа ч нүдний тухай өгүүлэхдээ огт өөр дүрслэлээр боловч үүргээр дүйцүүлэн орчуулсан байна гэж хэлж болохоор байна. Үүргийн хувьд дүйлгэх үзэл баримтлал нь (концепция функциональной эквивалентности) тухайн орчуулга дүйж байна уу үгүй юу гэдгийг эх орчуулга хоёрыг харьцуулж бус орчуулгыг уншигч, эх бичгийг уншигч хоёрын сэтгэгдлийг харьцуулахыг санал болгодог байна.⁹⁵ Хэрвээ сэтгэгдэл нь адил байвал орчуулгыг эх бичигтэйгээ дүйхээр болжээ гэж үзэх хэрэгтэй ажээ.

Харин эх шүлгийн гуравдугаар мөр буюу,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд- гэсэн мөрийг үндсээр нь өөрчлөн бүсгүйн гоолиг биеийн дүрслэл болгон хувиргахдаа дээлийг “тэрлэг” болгож тухайн мөрийн утгыг нарийвчлан гаргахыг оролджээ.

Мөн дөрөвдүгээр мөр буюу,

Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд - гэсэн мөрийг

Халуухан болоод энхрийхэн энхрийлэлтэд гэнэн залуу нас ичингүйрнэ - гэж эхээс огт өөр маягаар дүрсэлсэн боловч ямартаа ч ичингүйрлийн тухай санаа хадгалагдаж үлдсэн байна. Тэрлэг гэдэг үгийг “терлик” буюу галигчлан буулгаж оруулаад ямар нэгэн зүүлт тайлбарыг оруулж бичээгүй байна. Терлик гэж галигласан үгийг С.И Ожеговын толь бичгээс харахад ийм үг огт байхгүй байна. Эх шүлгийн утгатай хамгийн сайн дүйж байгаа мөр нь энэ бадагт хамгийн сүүлчийн мөр л байна. Гэхдээ эх шүлэгт байгаа бүсгүйн “сайхан” гэдэг утга нь гээгдэн, монгол бүсгүй болж өөрчлөгдсөн байна.

Наймдугаар бадаг буюу,

Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би:

Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд,

Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй

Тэнгээр говийн сүрэг онгон хулангийн нуруунд

Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би. – гэсэн мөрийг англи хэл рүү

Саймон: *I took my birth in the stirrups of a mighty riding-horse,*

⁹⁵ Г.Аким, Орчуулгын санг уудлахад, 1984 он, хуудас 11

*In the twitching forelock of an old ambler,
Seeing nothing more than the wind in the sky,
And, upon the smooth back of an ass, from a desert herd,
I took my birth in the stirrups of a mighty riding-horse.*— гэж буулгажээ.

Хэрвээ эдгээр мөрийг утгаар нь монголчилбол:

*Хүчирхэг хүлгийн дөрөөнд би төрлөө,
Хөгшин жороо морины шанхны чичиргээнд
Тэнгэрийн салхинаас бусдыг огт үзээгүй
Цөлийн сүрэг болох илжигний тэгшихэн нуруун дээр*

Хүчирхэг хүлгийн дөрөөнд би төрлөө— гэсэн үг юм. Эх шүлгийн хоёрдугаар мөрөнд байгаа “тэлмэн жороо” гэсэн хоршоо үгийг “хөгшин” жороо морь гэж орчуулсан байна. Орчуулагч яагаад ч юм тэлмэн гэдэг үгийг хөгшин гэж ойлгосон бололтой юм. Энэ үгийг Bawden-ын толь бичгээс сийрүүлэн харвал (усан) тэлмэн жороо буюу true ambler⁹⁶ гэж оноожээ. Тэлмэн гэдэг үгийг “Монгол хэлний хэл зүйн тайлбар толь”-ноос харахад үг нь байгаа боловч тайлбар хийгдээгүй байна. Ер нь бол энэ үг нь зөөлөн гэсэн утгатай аж. Тиймээс англиар gently ambling steed буюу зөөлөн жороолдог хүлэг гэж нийлэмж үгсээр орчуулбал утга нь илүү сайн гарч өгөх байсан болов уу.

Мөн дөрөвдүгээр мөр буюу,

Тэнэгэр говийн сүрэг онгон хулангийн нуруунд— гэсэн мөрийг

Цөлийн сүрэг болох илжигний тэгшихэн нуруун дээр— гэж орчуулжээ. “Тэнэгэр” болон “онгон” гэсэн тэмдэг нэрс нь гээгдээд, хулан нь “илжиг” болж хувирахдаа нуруу нь хүртэл “тэгшихэн” болсон байх юм. Эх шүлэг дээр ийм үг огт байхгүй бөгөөд ерөөсөө байхын ч аргагүй юм. Учир нь монголчууд морь юм уу хулангийн нурууны талаар тэгшихэн, толигор буюу smooth гэж огт ярьдаггүй. Англи орчуулган дээрээ ч бас эв хавгүй, хачин сонсогдож байна. Н.Доржготов багшийн “Англи-Монгол, Монгол-Англи аж ахуйн дүймэн” номноос энэ үгийг нягталж харсан боловч байхгүй байна. Тиймээс орчуулагч орчуулгын хэл зүйн хувиргал болох үг нэмэх аргыг хэрэглэн энэ үгийг оруулж ирсэн нь оновчгүй, илүүц хэрэг болсон байна.

Мөн wild гэдэг үгийг хаяснаас болж хуланг “илжиг” буюу “ass” болгож хувиргасныг эндүү харсан эсвэл хэтэрхий хайнга хандсанаас болж ийм ноцтой алдаа хийсэн байхаа гэж үзэж байна. Уг нь англиар хуланг wild-ass⁹⁷ эсвэл kulan⁹⁸ гэж хэлдэг. Харин нэг болон гуравдугаар мөрийн утга эх шүлгийн утгатай үнэхээр сайн дүйж байна. Букина энэ бадгийг,

Я родился хозяином диких коней ветрогривых.

Барабаном гигантским — земля под копытом игривым!

К водопою несутся куланы в гобийской пустыне —

¹⁶ Mongolian English Dictionary, Charles Bawden, 1997 он, хуудас369

⁹⁷ Charles Bawden, Mongolian English Dictionary, 1997 он, хуудас 470

⁹⁸ Гомбожав, Хангин, A Modern Mongolian English Dictionary, 1986 он, хуудас 685

Никого, кроме ветра, к себе не пускают на спину.

Да, владыкой коней ветрогривых на свет я родился!– буюу монголчилбол:

Салхин дэлт зэрлэг адууны эзэн нь болж би төрлөө

Аальгүй туурайн дор газар асар том бөмбөр болдог

Нуруундаа салхинаас өөрийг хандуулдаггүй (ойртуулдаггүй)

Хулангийн сүрэг говь цөлд ус руу давхиж байна

Тиймээ, салхин дэлт адууг эзэгнэгч болж хорвоод би төрлөө – гэж орос руу орчуулжээ. Орчуулгаас харахад эх шүлгийн эхний шадын тэнхээт хүлгийг зэрлэг адуу болгож авсан нь ойлгомжгүй байна. Манай оронд адуу эмнэгшинэ үү гэхээс зэрлэгшинэ гэж ер байдаггүй. Энэ бадагийн орчуулгаас зөвхөн гуравдугаар мөр буюу *нуруундаа салхинаас өөрийг ойртуулдаггүй* гэдэг мөр л эх шүлгийн утгатай дүйж байна. Бусад мөрүүдийн тухайд орчуулагч өөрөө зохиомжлон бичжээ гэж үзэж байна.

Ер нь “Дээр үеэс нааш голчлон ноёрхсоор ирсэн орчуулгын гурван арга байдаг. Үүнд: 1. чөлөөт орчуулгын арга 2. үгчлэх арга 3. төгс орчуулах эдгээр болно. Чөлөөт орчуулгын аргыг хэрэглэдэг хүмүүс дур зоргоороо аашилж, зохиогчийн санааг засамжлах, эх бичгээс нь ихээр зөрүүлж, шаардлагагүй газар үг, өгүүлбэр нэмж хасдаг.”⁹⁹ байна. Мөн “Чөлөөт орчуулгын аргатай тэмцэл хийхдээ зарим нэгэн орчуулагчид үгчилсэн орчуулгын замд хальтран ордог.”¹⁰⁰ ажээ. Дээр дурдсан эхний хоёр арга нь орчуулгын практикт цөөнгүй тохиолддог хэт туйлширсан хандлагууд юм байна. Тэгэхээр энэ онолын үүднээс харахад зарим талаараа Букина чөлөөт орчуулгын аргыг, харин Саймоныг Букинатай харьцуулахад үгчилсэн орчуулгын аргыг түлхүү баримтлан орчуулжээ гэж хэлэхэд болох мэт санагдана.

Дүгнэлт

Эцэст нь ерөнхийлөн дүгнэхэд “Би хаана төрөө вэ” шүлгийн орос орчуулга уран сайхны тал дээр хол илүү боловч утга дүйлгэцийн тал дээр эх шүлгээсээ нэлээн гажсан, орчуулагч хэтэрхий чөлөөт байдлаар хандаж, эх шүлгийн гол утга санааг гуйвуулсан зүйл чамгүй байна. Харин англи орчуулга нь орос орчуулгатай харьцуулахад эхдээ ойр боловч зарим талаараа эх шүлэгтээ хэтэрхий баригдмал шинжтэй, ташаа ойлгож манай үндэсний амьдралын хэв маяг, соёл, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг харгалзаж үзээгүй тал ажиглагдаж байна.

Утга зохиолын орчуулагч, даан ялангуяа шүлэг яруу найргийн орчуулагч хүн үргэлжилсэн буюу хүүрнэсэн үгийн зохиолын орчуулагчаас эрс ялгаатай, шүлгийн хэмнэл айзам, хэлбэр, өнгө аяс, дүр дүрслэлийн онцлог, өвөрмөц найруулгыг хадгалан буулгаж чадах онцгой мэдрэмжтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл Л. Букина Саймоныг

⁹⁹ Д. Дашдаваа “Орчуулгын зарим асуудал”, УБ, 1977 он, хуудас 29

¹⁰⁰ Д. Дашдаваа “Орчуулгын зарим асуудал”, УБ, 1977 он, хуудас 32

бодвол шүлгэнд үнэхээр мэдрэмж сайтай, төрөлхийн авьяастай хүн болох нь харагдаж байна.

Утга зохиол тэр дундаа шүлэг, яруу найргийг орчуулахдаа хэдий адил утгатай үгс мөн боловч тухайн хам эхэд сонгосон үгний эерэг болон сөрөг өнгө аястай утгын нарийн ялгаатай тал нь хэр тохирч байгааг сайтар нягталж байж үгээ зөв оноох нь зүйтэй болов уу.

Ном зүй

1. Аким.Г, Орчуулгын санг уудлахад, УБ, 1984 он
2. Аким.Г, Орчуулгын санг уудлахад, УБ, 2009 он
3. Google's, Wikipedia, Free Encyclopedia, History of English Language
4. Даидаваа. Д, Орчуулгын зарим асуудал, УБ, 1977 он
5. Доржготов.Н, Англи-Монгол, Монгол-Англи аж ахуйн дүймэн, 1999 он
6. Дулам. С, Хасбаатар. Ц, Уран зохиолын онолын үүд, УБ, 1980 он
7. Из монгольской поэзии XX века М., 1981 он
8. Литературная газета, №9. 3 марта 1982г
9. Мөнх.Ц, Б.Явуухулангийн яруу найргийн туршилага, УБ, 1990 он
10. Монголын орчин үеийн яруу найраг, Гадаадынхан монголын уран зохиолын тухай, УБ..1977
11. Монгол хэлний хэл зүйн тайлбар толь, УБ
12. New Oxford Advanced Learner's Dictionary, 2007
13. Орчуулах эрдэм, УБ, 1972 он
14. Ожегов.С.И Словарь русского языка, 1965 он
15. Oxford Advanced Learner's Dictionary of Current English AS Hornby, 2005
16. Russian-English Dictionary, М.,1965 он
17. Саймон Уикхэм Смит, Mongolian verse, the collected poems of Begziin Yavuuhulan, 2009 он
18. “Сэтгэл татах яруу найраг”, “Үнэн”, 1967 оны 7-р сарын 11 №192 10187
19. Charles Bawden, Mongolian-English dictionary 1997 он
20. Чуковский.К, Высокое искусство, М.,1964
21. Шархүү.А, Үндэстний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал, УБ, 2005 он
22. Явуухулан.Б, Түүвэр зохиол, УБ, 1985 он
23. Явуухулан.Б, Яруу найраг миний амьдралд, УБ, 1983 он

Summary

In this article, the author compared Mongolian original of the well-known poem ”Where I was born” of Begziin Yavuukhulan to English translation by Simon Smith and Russian translation by L.Bukina. Comparing only seventh and eighth stanzas of the poem, she touched upon some critical points of their work while mentioning their advantages at the same time and suggested possible versions of translations of those work.

Хавсралт:

Долдугаар бадаг: **Саймон**

Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би:

*Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд,
Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд,
Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд
Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би.*

I took my birth in the mind of a beautiful woman,

*In the tenderness of her gaze, among her lashes,
In the lapping folds of her deel, reeking of milk.
And, in her modesty, in her thoughts, and in her thoughts,
I took my birth in the mind of a beautiful woman.*

*Сайхан бүсгүйн бодолд би төрлөө,
Сормуусан дундах харцны нь ялдамханд
Сүүний үнэр нэвширсэн (!) дээлийнх нь өвөр хэсгийн нугалаасанд
Түүнийхээ даруухан зан, оюун бодол болон оюун бодолд нь
Сайхан бүсгүйн бодолд би төрлөө*

Долдугаар бадаг: **Букина**

Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би:

*Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд,
Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд,
Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд
Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би.*

Я владыкой любви темноглазой монголки родился,

Мягкий терлик вокруг ее тонкого стана обвился,*

Робкий взгляд ее светится мне сквозь ресницы,-

Ласк горячих и нежных наивная юность стыдится.

Да, владыкою сердца монголки на свет я родился!

*Хар нүдэн монгол бүсгүйн хайрыг эзэгнэгч болж би төрлөө
Зөөлөн тэрлэг нь туяхан гоолиг биеий нь барина
Сормуусан дундах аймхай нүд нь надад гэрэлтэнэ
Халуухан болоод энхрийхэн энхрийлэлтэнд гэнэн залуу нас ичингүйрнэ
Тиймээ, Монгол бүсгүйн зүрх сэтгэлийг эзэгнэгч болж энэ хорвоод би төрлөө*

Наймдугаар бадаг **Саймон**

*Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би:
Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд,
Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй
Тэнэгэр говийн сүрэг онгон хулангийн нуруунд
Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би.*

*I took my birth in the stirrups of a mighty riding-horse,

In the twitching forelock of an old ambler,
Seeing nothing more than the wind in the sky,
And, upon the smooth back of an ass, from a desert herd,
I took my birth in the stirrups of a mighty riding-horse.*

*Хүчирхэг хүлгийн дөрөөнд би төрлөө,

Хөгшин жороо морины шанхны чичиргээнд
Тэнгэрийн салхинаас бусдыг огт үзээгүй
Цөлийн сүрэг болох илжигний тэгжихэн нуруун дээр
Хүчирхэг хүлгийн дөрөөнд би төрлөө— гэсэн үг юм.*

Наймдугаар бадаг **Букина**

*Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би:
Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд,
Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй
Тэнэгэр говийн сүрэг онгон хулангийн нуруунд
Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би.*

*Я родился хозяином диких коней ветрогривых.

Барабаном гигантским — земля под копытом игривым!*

К водою несутся куланы в гобийской пустыне —

Никого, кроме ветра, к себе не пускают на спину.

Да, владыкой коней ветрогривых на свет я родился!

Салхин дэлт зэрлэг адууны эзэн нь болж би төрлөө

*Аальгүй туурайн дор газар асар том бөмбөр болдог
Нуруундаа салхинаас өөрийг хандуулдаггүй (ойртуулдаггүй)
Хулангийн сүрэг говь цөлд ус руу давхиж байна*

Тиймээ, салхин дэлт адууг эзэгнэгч болж хорвоод би төрлөө

B. YAWUUKHULAN

БИ ХААНА ТӨРӨӨ ВЭ

Translated by D.Altangerel

WHERE WAS I BORN

I was born owning the boundless sky,

In the distant circuit where voyages the crescent moon,

In the smallest space where two remote stars draw nigh,

I was born owning the boundless sky

In the bluest spot my eyes could have seen.

I was born owning a mountain with the pure white snow,

On the summit where curl the clouds and steams the rime,

On the glacier-laden slope where the snowflakes frost and glisten,

I was born owning the mountain with the pure white snow

Where the yak bulls bellow and snort in the coldest winter.

I was born owning the virgin and azure steppe,

In a valley where delude dim grey spring mirages,

In a dale where a bull camel's teeth are heard in winter,
I was born owning the virgin and azure steppe
Where the traces of dinosaurs remain till today.

I was born owning the rivers and streams
In the waves where delicately floats the shadow of the silver moon,
I was born owning the rivers and streams of holy water
That washed up the earth of strange countries
Stuck to the hooves of my ancestors' steeds.

I was born owning the sweet smelling wormwood and thyme,
In a leaf where the dew falls on the verge of the night and dawn,
In a petal of a flower where dewdrops reflect the stars,
In the edelweiss, a symbol of an eternal life
I was born owning the sweet smelling wormwood and thyme.

I was born owning a white ger like a sleeping swan,
In the seamless felt coverings and graceful ropes,
In the base of steel hearth with kindled red flames,
I was born owning thw white ger like a sleeping swan,
To which the Mongolians have been accustomed for hundreds of years.

I was born owning a beautiful woman's heart,
In the amorous look of the hazel eyes which swim beneath their lashes,
In the folds of a maid's garment from which came the scent of milk,

I was born owning a beautiful woman’s heart
With bashful but faithful character and thoughtful tenderness.

I was born owning a mighty and strong steed,
In the smooth rhythm of the even-gaited horse,
On the wild ass’s back, a beast of the vast Gobi,
That never allowed anyone other than the heavenly winds to ride,
I was born owning the mighty and strong steed.

I was born owning the heavy rain and showers,
In the thunderclap and lightning which alarmed the peaceful sky,
In a pearly drop from the hail whistling in the clear air,
In the seven colours of a rainbow that appeared across the golden steppe,
I was born owning the heavy rain and showers.

I was born owning the melodious songs and music,
In the drink of a silver cup with a blue silk khadag,
In the tunes of our folk-songs which move our hearts,
In man’s fate that combines endurance and happiness,
I was born owning the melodious songs and music.

I was born owning an able man’s body,
In the heart of like-minded people for their Mongolia,
In the fire with red flames from the tall factor chimney,
That blazes demanding ore at the balck dawn,

I was born owning the man’s body.

I was born owning a land of the blue sky,

In a traditional legend of the famous Blue Mongolia,

In a flame of the revolution which was won in the country of mighty ancestors,

I was born owning the land of the blue sky-

The wrinkled forehead of the golden world.

B. YAWUUKHULAN

БИ ХААНА ТӨРӨӨ БЭ

Translated by N.Oyun-Undraa

WHERE WAS I BORN

I was born reigning over the clear sky of deepest blue.

In the yonder orbit the moon in the shape of eyebrow travels,

At the slightest chance the two removed stars yoke together,

In the distance that barely blues onto the tip of my vision

I was born reigning over the clear sky of deepest blue.

I was born reigning over the snowy-white mountains.

At the peak wreathed in clouds steaming hoarfrosts,

At the precipice the snowflakes are frozen to ice via congealing

And a yak bull climbs up in the harshly cold winter

I was born reigning over the snowy-white mountains.

I was born reigning over the virgin bluish steppe.

In the valley the ashen grayish mirage blurs by the spring,

In the gorge the teeth of the male-camel in a rut rattle

by the perishing cold winter

And the traces of dinosaurs have remained up to now

I was born reigning over the virgin bluish steppe.

I was born reigning over the water of the rivers.

In the wave the shadow of the silvery moon floats on its surface

And had washed the foreign soil with its holy water

That was stuck on the hooves of the horses of my ancestors

I was born reigning over the water of the rivers.

I was born reigning over the sweet smelling wormwood Artemisia and Thyme

On the leaf the dews fall by the crack of dawn,

On the petal with pearly dews, stars dazzle in,

In the edelweiss that is the symbol of deathless infinity

I was born reigning over the sweet-smelling wormwood Artemisia and thyme

I was born reigning over the ger like a dozing swan

In the seamless white urkh's rope twisted with double thread

In the lintel of the steel brazier with the heart-shaped ruddy fire

Where Mongolians have been accustomed to living for hundreds of years

I was born reigning over the ger like a dozing swan.

I was born reigning over the beautiful lady's heart.

In the welling up of the eyes with double-lids that flutter lashes,

In the crease of the deel-skirt redolent of the smell of milking

In the purely shy mood that tears at my heartstring when reminiscing

again and again

I was born reigning over the beautiful lady’s heart.

I was born reigning over the stirrups of a muscular steed.

In the trembling of the frontal hair tips of a gently ambling steed,

On the back of the virgin wild horses becoming a herd of the vast Gobi

That have never been mounted by anybody but the wind of the sky.

I was born reigning over the stirrups of a muscular steed.

I was born reigning over the downpours and rainfalls.

In the terrible lightning of thunderbolt that jolts the tranquil sky

In the white hailstones that parachute in the heavenly air

In the seven colors of rainbow that arch over the golden steppe.

I was born reigning over the downpours and rainfalls.

I was born reigning over the melody of the song of crystal clearness

In the vodka in the silver bowl upon the ceremonial silky scarf

To the music of the long song with the smoothly flowing tune

In a man’s destiny coupled the joys and the sorrows

I was born reigning over the melody of the song of crystal clearness.

I was born reigning over the body of a resourceful one.

In the heart of the people with a single life for Mongolia

In the tongue-shaped red fire of the tall chimney of a factory

That blazes up clamoring for the ore by the break of dawn.

I was born reigning over the body of a resourceful one.

I was born reigning over the country of the bright blue sky.

In the legends about how the Blue Mongolians gained fame, passed onto the generations to generations

In the flame of the revolution, won in the country of the powerful ancestors

That became the seamed and wrinkled forehead of the earthen golden world

I was born reigning over the country of the bright blue sky.